



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/214

Арвайхээр

Ээлжит цэрэг татлага явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны мн/209 дүгээр тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн н/60 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын ажлыг сумдаар 04 дүгээр сарын 19-ний өдрөөс 04 дүгээр сарын 29-нд, цэрэг татлагын эрүүл мэндийн нэгдсэн үзлэгийг 04 дүгээр сарын 30-наас 05 дүгээр сарын 01-ний өдрүүдэд тус тус зохион байгуулсугай.

2.“Цэрэг татлага явуулах хуваарь”-ийг 1 дүгээр, “Эрүүл мэндийн үзлэг хийх эмч нарын комиссын бүрэлдэхүүн”-ийг 2 дугаар, “Цэрэг татлагын үйл ажиллагаанд шаардагдах төсөв”-г 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Цэрэг татлагын товчооны дарга (Ц.Ганболд )-д ДААЛГАХ нь:

а.Цэрэг татлагын ажлыг Цэргийн штабын даргаар ахлуулж батлагдсан хуваарийн дагуу тухайн сумдад зохион байгуулан ажиллуулах.

б.Цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж, цэрэг татлагын үед сахилга хариуцлага, дэг журам, техникийн бүрэн бүтэн байдлыг хангуулах бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

в.Цэрэг татлагаар их, дээд сургуулиудын дөрөвдүгээр дамжаа буюу төгсөх дамжааны оюутнуудыг дуудахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авах.

4.Эрүүл мэндийн үзлэгээр явах эмч нарыг үүрэг даалгавраар хангаж, эмнэлгийн фургон УАЗ-452 авто машин (1 нэгж)-ийг 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 04 дүгээр сарын 29-ний өдрийг дуустал хугацаанд гаргаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал (Г.Дашжанцан)-д даалгасугай.

5.Цэрэг татлагын үйл ажиллагаанд зарцуулах 7,405,800 (долоон сая дөрвөн зуун таван мянга найман зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын бараа үйлчилгээний бусад зардлаас гаргаж, зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд )-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0398  
D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 2 дугаар  
сарын 11-ны өдрийн 2 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт



ЦЭРЭГ ТАТЛАГЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ ХИЙХ ЭМЧ  
НАРЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

№	Эмч нарын хуваарь	Эмч нарын нэр
2023.04.19-2023.04.29		
1	Ерөнхий эмч	Д.Энхбаатар
2	Нүдний эмч	Г.Золзаяа
3	Шүд, чих, хамар, хоолойн эмч	Б.Цэндсүрэн
4	Мэдрэлийн эмч	Б.Амбасэлмаа
5	Сүрьеэгийн эмч	Ч.Оюунжаргал
6	Дотрын эмч	
7	Мэс заслын эмч	Ц.Намжилмаа
8	Арьс өнгөний эмч	Б.Ууганчимэг
9	Жолооч (ӨВА 56-31)	А.Ганболд

-oOo-

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дугаар  
сарын 19-ны өдрийн 100 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт



## 2023 ОНЫ НЭГДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН ХУВААРЬ

Д/д	Сум	Он, сар, өдөр	Цаг	
			Эхлэх	Дуусах
1	Арвайхээр	2023.04.19, 20	08:30	18:00
2	Гучин-Ус	2023.04.21	08:30	18:00
3	Богд	2023.04.22	08:30	18:00
4	Баруунбаян-Улаан	2023.04.23	08:30	18:00
5	Нарийнтээл	2023.04.24	08:30	18:00
6	Хайрхандулаан	2023.04.25	08:30	18:00
7	Тарагт	2023.04.26	08:30	18:00
8	Уянга	2023.04.27	08:30	18:00
9	Бат-Өлзий	2023.04.28	08:30	18:00
10	Хужирт	2023.04.29	08:30	18:00

ЦЭРГИЙН ШТАБ

Аймгийн Засаг даргын 2023 оны 14 дугаар сарын 2...-ны өдрийн 14/2023 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт

2023 ОНЫ НЭГДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО

1. Шатах тослох материалын тооцоо

№	Зориулалт	Машин			Шаардагдах ШТМ		Нэгжийн үнэ		Бүгд үнэ		Нийт үнэ
		марк	тоо	явах км	А-92 (л)	Масло (л)	А-92 (л)	Масло (л)	А-92 (л)	Масло (л)	
1	10 сумаар тойрч цэрэг татлага явуулах	Ланд-105	1	950	190		2470	-	469,300	-	469,300
2	Цэрэг татлагын товчоонд шаардагдах	Фургон машин	1	950	190	1	2470	12,800	469,300	12,800	482,100
3	Цэрэг татлагын ЗХЖШ, ХХЕГ-т цэрэг татлагын дүн мэдээг хүргэж өгөх	Ланд-105	1	100	20	-	2470	-	49400	-	49,400
	Дүн	Приус-20	1	1000	100	-	2470	-	247,000	-	247,000
			4	3000	500	1	2470	12,800	1,235,000	12,800	1,247,800

2. Томилолтын төсөв

Д/д	Албан тушаал	Суманд				Томилолтын зардал
		хүний тоо	ажиллах хоног	нэг хоногийн томилолт	Томилолтын зардал	
1	Эмч нарын томилолт	10	10	24,000	2,400,000	
2	Цэргийн штабын офицерууд, жолоочийн томилолт	4	10	24,000	960,000	
3	ЗХЖШ, ХХЕГ-т дүн мэдээ өгөх томилолт	2	2	142,000	568,000	
	Дүн	16	12	190,000	3,928,000	

## 3. Хоолны төсөв

д/д	Зориулалт	Хүний тоо	Хэдэн удаа	Нийт хүн	Үнэ	Нийт үнэ
1	Цэрэг татлагын комисс	14	3	42	10000	420,000
2	Цэрэг хүргэж ирсэн офицеруудыг хооллох	12	6	72	10000	720,000
3	Хилийн цэргийн ангийн удирдлагыг байрлуулах зардал	2	2 хоног	2	100,000	200,000
4	Дүн	28	11	116	120,000	1,340,000

## 4. Сурталчилгааны материал хэвлүүлэх

д/д	Хэвлүүлэх материал	Хэвлүүлэх тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Цэргийн алба хаах хэлбэрээр тараах материал, гарын авлага	300	1000	300,000
2	Цэрэг татлагын байранд аннос, сурталчилгааны самбар хийж байрлуулах	1	20,000x15м2	300,000
	Дүн	301	-	600,000

## 5. Халдвар хамгаалал, ариутгалын материалын төсөв

д/д	Материалын нэр	Ажиллах хүний тоо	1 өдөрт хэрэглэх тоо	Ажиллах хоног	Нийт тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Үзлэгийн бээлий (50 хос)	10	1 хайрцаг	10	10	20 000	200,000
2	Гар ариутгагч/санитоль	10	1	10	10	5000	50,000
3	Амны хаалт	10	2	10	200	200	40,000
	Дүн	30	4	30	220	-	290,000

Цэрэг татлагын нийт зардал 7,405,800 төгрөг